



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/535

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил" болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийн хавсралтад тусгагдсан 17 дахь арга хэмжээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд сонин хэвлүүлэхэд 6,000,000 (зургаа сая), Арвайхээр сумын хүнсний захын мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид анхан шатны шинжилгээний багаж худалдан авахад 5,000,000 (таван сая), төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101100